



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 8319


Улаанбаатар хот

Г Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрэм
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Дүрэм батлах тухай” 33 дугаар тогтоол Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрмийг нэгдүгээр, Сувилагчийн тангарагийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг улсын хэмжээнд сурталчлан танилцуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хяналтын хороо /Д.Оюунбилэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дүгээр
сарын 16-ний өдрийн 4319 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

СУВИЛАХҮЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Сувилахуйн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах харилцаа, хандлага, ёс суртахууны хэм хэмжээг энэхүү сувилахуйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулна.
- 1.2 Энэхүү ёс зүйн хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон Монгол улсын хүлээн зөвшөөрч нэгдсэн хүний эрх, эрх чөлөөний талаарх олон улсын эрх зүйн баримт бичиг Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн хэм хэмжээ, болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгээр тодорхойлогоно.
- 1.3 Эрүүл мэндийн байгууллага, тэдгээрийн дэргэд ажиллаж буй ёс зүйн хороо, баг нь энэхүү хэм хэмжээг сурталчлан мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, эрх хэмжээний хүрээнд ажиллана.

Хоёр. Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний хамрах хүрээ

- 2.1 Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ нь сувилахуйн мэргэжлийн тусlamж үйлчилгээ үзүүлдэг эрх бүхий мэргэжилтнүүдийн (сувилахуйн алба болон сувилахуйн багт харьялагдах) ёс суртахууны харилцааг зохицуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэн, мэргэжлийн нэр төрийг хамгаалахад оршино.
- 2.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн мэргэжилтнүүд энэхүү ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллана.

Гурав. Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний зарчим

- 3.1 Хүнлэг энэрэнгүй үнэнч шударга байж, хүний нэр төр, язгуур эрх ашгийг хүндэтгэнэ.
- 3.2 Хүн бүрт тэгш хандаж, хувь хүний нууцыг хамгаална.
- 3.3 Сувилахуйн тусlamж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс сэргийлэн үүрэг хариуцлагаа ухамсарлан ажиллана.
- 3.4 Сувилахуйн мэргэжлийн үнэ цэнэ, нэр төр, мэндлэх, хүндлэх ёсыг эрхэмлэн ажиллана.
- 3.5 Сувилахуйн мэргэжилтэн нь мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн тасралтгүй суралцаж өөрийгөө хөгжүүлнэ.

Дөрөв. Сувилахуйн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээ

- 4.1 Сувилахуйн ухааны үзэл баримтлал нь амьдралыг тэтгэгч, хүний эрүүл мэнд энх байдал, нэр төр, язгуур эрх ашгийг эрхэмлэн хүндэтгэсэн энэрэнгүй байна.
- 4.2 Сувилахуйн мэргэжилтэн нотолгоонд суурилсан шинжлэх ухааны үндэслэлтэй тусламж, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлнэ.
- 4.3 Сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн холбогдох стандарт, заавар, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, чанартай тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- 4.4 Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн бүртгэл, маягтыг журмын дагуу үнэн зөв, бүрэн гүйцэд хөтөлж тэмдэглэл хийнэ.
- 4.5 Сувилахуйн мэргэжилтэн мэдлэг, ур чадвараа сайжруулахын тулд эмнэлзүйн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, мэргэжлийн болон ёс зүйн сургалтанд тасралтгүй суралцдаг байна.
- 4.6 Сувилахуйн удирдлага, эрдэм шинжилгээ, судалгаа хийх болон сувилахуйн боловсролыг тодорхойлох, сувилахуйн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд санаачлага, идэвх зүтгэлтэй оролцоно.
- 4.7 Сувилахуйн мэргэжилтэн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, халдвартын сэргийлэлт, хяналтыг баримтлан ажиллана.
- 4.8 Сувилахуйн мэргэжилтэн байгууллагын үнэт зүйлс, соёлыг эрхэмлэн, ажлын байранд зөрөг уур амьсгалыг бүрдүүлэн ажиллана.
- 4.9 Сувилахуйн мэргэжилтэн байгууллагынхаа ёс зүйг хэвшүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, ёс зүйн эрсдэл, алдаа болон бусад эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, бүртгэж мэдээлдэг байна.
- 4.10 Тусламж үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчээс шан харамж, авилга авах зэрэг сэдэл төрүүлэхгүй байна.
- 4.11 Сувилахуйн мэргэжилтэн нийгэм, хүрээлэн буй орчны эрүүл мэндэд аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцоно.
- 4.12 Сувилахуйн мэргэжилтэн эрүүл мэнд, эмнэлгийн мэргэжлийн бусад нөхөдтэйгээ хамтран ажиллаж, тэдний мэргэжлийн эрхийг хүндэтгэнэ.
- 4.13 Сувилахуйн болон бусад мэргэжлийн ажиллагсадтай хүндэтгэлтэй харилцаж, хамтын ажиллагааг дэмжин ажиллана.
- 4.14 Байгууллагын өмч хөрөнгө, эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийн нөөцийг шамшигдуулахгүй, тэгш хүртээмжтэй ашиглана.
- 4.15 Сувилахуйн мэргэжилтэн мэргэжлийн нэр хүндийг хамгаалж, үйлчлүүлэгч, олон нийтийн итгэл, хүндэтгэлийг хүлээж, хувийн соёлыг эрхэмлэн ажиллана.
- 4.16 Сувилахуйн мэргэжилтэн ажлын байран дээрээ хайнга, хэнэггүй байдлыг үйлдлээрээ гаргах, бусадтай зүй бусаар харилцах, бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй биеэ зөв авч явах соёлыг хэвшүүлнэ.
- 4.17 Сувилахуйн мэргэжилтэн тусламж үйлчилгээний явцад гарсан аливаа асуудалд хүлээцтэй хандаж, анхааралтай сонсож, зөрөг талаас нь шийдвэрлэнэ.
- 4.18 Сувилахуйн мэргэжилтэн үзүүлж буй тусламж үйлчилгээнд үүргээ ухамсарлан, хариуцлагатай хандаж, аливаа асуудлыг нуун дарагдуулахгүй мэдээлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэн үнэнч шударгаар ажиллана.

Тав. Сувилахуйн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харилцах хэм хэмжээ

- 5.1 Сувилахуйн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй энэрэнгүй эелдэг зөвлөн хүндэтгэлтэй харилцаж, аюулгүй, чанартай, үр ашигтай сувилахуйн тусlamж үйлчилгээ үзүүлнэ.
- 5.2 Сувилахуйн мэргэжилтэн үйлчлүүлэгч бүрт эрх тэгш, шударга хандана.
- 5.3 Сувилахуйн мэргэжилтэн эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх бүрт үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган ажиллана.
- 5.4 Сувилахуйн мэргэжилтэн тусlamж үйлчилгээ үзүүлэхийн өмнө тайлбарлан ойлгуулж, итгэл үнэмшийг төрүүлэн чин сэтгэлээсээ хандана.
- 5.5 Сувилахуйн мэргэжилтэн үйлчлүүлэгчийнхээ сувилахуйн тусlamж үйлчилгээний талаар ярилцан, түүнд ойлгомжтой байдлаар тайлбарлана. Хэрэв үйлчлүүлэгч хэлний болон харилцааны бэрхшээлтэй бол аль болох ойлголцож чадахуйц байхыг хичээнэ. Шаардлагатай тохиолдолд гэр бүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс туслалцаа авна.
- 5.6 Сувилахуйн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн зовиур шаналгаа, зовлон, уй гашууг нь хуваалцах, өрөвч зөвлөн сэтгэлтэй, ухаалаг зан чанартай байж, гэр бүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, төрөл төрөгсөдтэй харилцааны хэм хэмжээнд ойлголцож ажиллана.
- 5.7 Сувилахуйн тусlamж үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн бие даасан байдал, сонголт, итгэл үнэмшил, сүсэг бишрэлийг хүндэтгэн харилцаж, тайлбарлах ба татгалзсан шийдвэрийг зохих журмын дагуу хариуцсан албан тушаалтанд мэдэгдэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны дүгээр
сарын..*16*...-ний өдрийн *06* дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

СУВИЛАГЧИЙН ТАНГАРАГ

СУВИЛАГЧ БИ,

ХҮНЛЭГ ЭНЭРЭНГҮЙ, ЭЕЛДЭГ ЗӨӨЛӨН, ҮНЭНЧ ШУДАРГА БАЙЖ
ХҮН АРДЫНХАА ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХЫН ТӨЛӨӨ
ЭРДЭМ МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДАЙЧЛАН АЖИЛЛАХ МЭРГЭЖИЛТЭН
БАЙХАА

ЭХ ОРОН, АРД ТҮМЭНДЭЭ АНДГАЙЛАН

ТАНГАРАГЛАЯ

ТАНГАРАГЛАЯ

ТАНГАРАГЛАЯ

Монголын сувилагчдын эрхэмлэх ёс зүй

- Сувилахуйн ухааны үзэл баримтлал нь амьдралыг тэтгэгч, хүний эрүүл энх, сайн сайхан аж амьдрал, нэр төрийг эрхэмлэн хүндэтгэх явдал мөн.
- Сувилагчид нь ард түмнийхээ эрүүл мэндийг сайжруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлсэд өөрсдийн хүлээх хариуцлагыг өндөржүүлэх, сувилахуйн соёл, үйлчилгээний чанарын стандартыг дээшлүүлэхэд эрхэмлэж явах “Сувилагчдын эрхэмлэх ёс зүй”-г баримтлан ажиллана.
- Сувилагч нь баян ядуу, гарал үүсэл, шашин шүтлэг, нийгмийн байдааар ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд тулгуурлан сувилахуйн тусламжийг үйлчлүүлэгчдэд жигд хүртээмжтэй үзүүлнэ.
- Сувилагч нь нийгмийн эрүүл мэндийг дэмжиж, ард түмнийхээ эрүүл энхийн төлөө өөрийн мэдлэг, мэргэжил, авьяас чадварыг дайчлан ажиллана.
- Сувилагч нь өвчтөний зовиур шаналгаа, зовлон уй гашууг нь хуваалцах, өрөвч зөөлөн сэтгэл, ухаалаг шийдэмгий зан чанартай үнэнч туслагч, сайн нөхөр нь байж өвчтөний сэтгэл санааг ялан дийлэх үзлээр зорижуулахад гэр бүл төрөл төрөгсөдтэй нь хамтран ажиллана.
- Сувилагч нь үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг дээдэлж, аливаа нууцлалыг нь хадгалж, өвчтөнд хандах хандлага, үйлдэл, үйл ажиллагаандаа хувийн дүгнэлтийг мэргэжлийн түвшинд гаргаж, хүлээх хариуцлагаа ухамсарлан ойлгож ажиллана.
- Сувилагч нь сувилгааны стандартыг хэрэгжүүлэгч, бүтээгч нь байж боловсролоо байнга дээшлүүлэн эрдэм шинжилгээ судалгааны ажил, сувилахуйн шинжлэх ухааныг Монгол улсад хөгжүүлэх үйлсэд зориг санаачлага, идэвх зүтгэлтэй оролцно.
- Сувилагч нь эрүүл мэнд, эмнэлгийн мэргэжлийн бусад нөхөдтэйгээ хамтран ажиллаж, тэдний мэргэжлийн эрхийг хүндэтгэнэ.

Сувилагчийн энэхүү эрхэмлэх ёс зүйг Монгол улсын нийт
Сувилагч нар хүндэлтүгэй, дээдэлтүгэй.